



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/56/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: Bat-rdenes@audit.gov.mn
Шонхор үнэлгээ аудит ХХК-ийн захирал: Д.Шийрэв
Утас: 88880963 Цахим хаяг: Shonkhor.mn@gmail.com

Улаанбаатар хот
2024 он

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Зээлийн батлан даалтын сан, түүний үйл ажиллагаа	10
3.2 Зээлийн батлан даалтын сангийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж.....	17
1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал.....	17
2. Өр төлбөртэй холбоотой асуудал.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	20
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
СЯ	Сангийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УЗ	Удирдах зөвлөл
ХДК	Хадгаламжийн даатгалын корпораци
ХХААЯ	Хүнс хөдөө аж ахуйн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН
САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ЦОГТСАЙХАН ТАНАА

2024.03.25 № 07/843

танай -ны № -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Зээлийн батлан даалтын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 4,524.6 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.6, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2, 6.4.8-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Зээлийн батлан даалтын сангийн нягтлан бодох бүртгэлийн Даймонд программын мэдээллийн бааз 2024 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр ransomware төрлийн халдлагад өртөж, санхүүгийн тайлан бэлтгэх боломжгүй болсон бөгөөд байгууллагын санхүүгийн ажилтнууд 2023 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл, холбогдох бүх гүйлгээг программ руу дахин оруулж санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудал

МУЗГ-аас хэрэгжүүлж буй "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө"-ний "Ажлын байрыг дэмжих" зээлийг батлан даахад зориулсан 2021 оны 12/02-02 дугаартай гэрээний дагуу тайлант онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Хадгаламжийн даатгалын корпорацад 5,000.0 сая төгрөгийг шилжүүлж тус сангийн санхүүгийн тайланд тусгасан байна. Сангийн Удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор "Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт батлан даалт гаргах хамтран ажиллах гэрээ"-г арилжааны банкуудтай байгуулж ажиллахыг Сангийн гүйцэтгэх захиралд зөвшөөрснөөр энэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сангийн Удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор "Сангийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 6 бүлэг, 13 чиглэлийн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2023 оны 5 дугаар тэмдэглэлээр 91.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний эдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	159,127,070,902.30	186,852,736,031.05
1.1.4	Бусад авлага	49,556,840,533.44	27,581,234,154.39
1.1.6	Бараа материал	49,378,915.27	58,838,509.27
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,290,674,733.99	2,290,674,733.99
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	211,023,965,085.00	216,783,483,428.70
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,309,374,087.33	2,268,520,696.90
1.2.2	Биет бус хөрөнгө	48,371,133.31	33,885,867.66
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	45,000,000,000.00	40,000,000,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	47,357,745,220.64	42,302,406,564.56
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	258,381,710,305.64	259,085,889,993.26
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,521,867,214.19	4,514,309,973.58
2.1.1.3	Татварын өр		2,695,041.89
2.1.1.4	НДШ-ийн өглөг		3,868,700.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	268,783,701.67	318,417,066.07
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,790,650,915.86	4,839,290,781.54
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	129,800,945,947.06	129,800,945,947.06
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	45,150,000,000.00	40,050,000,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	174,950,945,947.06	169,850,945,947.06
2.2	Өр төлбөрийн нийт дүн	179,741,596,862.92	174,690,236,728.60
2.3	Цэвэр хөрөнгө		
2.3.1	Нөөц: а) Хязгаарлалтгүй	13,949,037,052.59	17,249,037,052.59
2.3.2	б) Хязгаарлалттай		
2.3.4	Цэвэр хөрөнгийн бусад хэсэг	59,200,000,000.00	60,000,000,000.00
2.3.5	Хуримтлагдсан үр дүн	5,491,076,390.13	7,146,616,212.07
2.3.6	Цэвэр хөрөнгийн дүн	78,640,113,442.72	84,395,653,264.66
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	258,381,710,305.64	259,085,889,993.26

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны орлого		
2	Бусад орлого	12,155,931,562.35	11,945,688,077.80
3	Үйл ажиллагааны орлогын нийт дүн	12,155,931,562.35	11,945,688,077.80
4	Ерөнхий удирдлагын зардал		
5	Цалин хөлс, шагнал	1,208,803,488.79	1,636,563,118.29
6	Нийгмийн даатгалын шимтгэл	151,406,987.20	208,410,936.99
7	Засвар үйлчилгээний зардал	47,513,219.18	57,516,028.20
8	Ашиглалтын зардал	8,345,293.00	12,264,560.00
9	Түрээсийн зардал		2,394,100.00
10	Албан томилолтын зардал	86,188,635.04	130,608,340.00
11	Элэгдлийн зардал	155,250,426.81	146,895,186.08
12	Зар сурталчилгааны зардал		86,031,426.23
13	Шуудан холбооны зардал		11,059,690.49
14	Шатахууны зардал		31,784,141.00
15	Зээлийн хүүгийн зардал	1,446,503,472.74	2,740,634,654.91
16	Бусад зардал	532,903,593.56	1,124,674,079.13
17	Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн	3,636,915,116.32	6,188,836,261.32
18	Үндсэн үйл ажиллагааны үр дүн	8,519,016,446.03	5,756,851,816.48
19	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(4,445,558.50)	
20	Балкютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)		(1,311,994.54)
21	Тайланд үеийн цэвэр үр дүн	8,514,570,887.53	5,755,539,821.94

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хязгаарлалтгүй нөөц	Цэвэр хөрөнгийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	58,000,000,000.00	10,161,858,157.34	3,146,428,918.07	71,308,287,075.41
2	Залруулсан үлдэгдэл	58,000,000,000.00	10,161,858,157.34	3,146,428,918.07	71,308,287,075.41
3	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	1,200,000,000.00			1,200,000,000.00
4	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	59,200,000,000.00	13,949,037,052.59	5,491,076,390.13	78,640,113,442.72
5	Залруулсан үлдэгдэл	59,200,000,000.00	13,949,037,052.59	5,491,076,390.13	78,640,113,442.72

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

6	Тайлант оны өсөлт/бууралт	800,000,000.00	3,300,000,000.00	(4,100,000,000.00)	
7	Тайлант үеийн цэвэр үр дүн			5,755,539,821.94	5,755,539,821.94
8	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,000,000,000.00	17,249,037,052.59	7,146,616,212.07	84,395,653,264.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	(төгрөгөөр)	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,174,642,320.64	36,982,197,892.60
	Бусад	2,174,642,320.64	36,982,197,892.60
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,444,041,326.67	13,885,417,180.09
1.2.1	Ажиллагсад төлсөн	963,098,722.00	869,630,762.75
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	287,723,858.34	385,501,597.61
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	106,313,890.00	3,394,797,983.41
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,600,000.00	
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		199,172,085.38
1.2.6	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	103,693,577.30	8,301,841,009.23
1.2.7	Хүүгийн төлбөрт төлсөн	2,473,173,625.14	
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	505,437,653.89	734,473,741.71
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,269,399,006.03	23,096,780,712.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1.3	Худалдсан хөрөнгө оруулалтын орлого	70,000,000.00	
2.1.4	Худалдаж авсан хөрөнгө оруулалт	3,799,800.00	107,219,410.00
2.2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	66,200,200.00	(107,219,410.00)
3.1.2	Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр		2,394,100.00
3.1.6	Хүү ба урамшууллын орлого	25,407,931,892.56	4,739,791,020.55
3.1.7	Валютын ханшны зөрүүгийн гарз	1,598,293,418.43	1,293,094.30
3.2	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	23,809,638,474.13	4,736,103,826.25
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	21,606,439,668.10	27,725,665,128.75
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	137,520,631,234.19	159,127,070,902.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159,127,070,902.30	166,652,736,031.05

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Хэтрэлт/Хэм нэлт	Хувь
Орлого					
1	Батлан даалтын шимтгэлийн орлого	787,381.6	864,232.3	76,850.7	109.7
2	Хураамжийн орлого	11,400.0	9,820.0	(1,580.0)	86.1
3	Хадгаламжийн хүүгийн орлого	10,384,755.1	10,934,195.9	549,440.8	105.3
4	Үйл ажиллагааны бусад орлого	131,756.7	137,452.2	5,695.5	104.3
	Нийт орлогын дүн	11,315,293.4	11,945,700.4	630,407.0	105.6
Зардал					
	Үйл ажиллагааны зардал				
1	Цалин	1,692,040.0	1,655,877.1	(36,162.9)	97.8
2	НДШ	215,634.7	210,825.2	(4,809.5)	97.8
3	Нэг удаагийн тэтгэмж	224,720.0	147,610.9	(77,109.1)	65.7
4	Шагнал урамшуулал	6,080.0	126.0	(5,954.0)	2.0
5	Бичиг хэрэг	24,999.6	21,484.2	(3,515.4)	85.9
6	Шатах тослох материал	33,208.1	31,784.1	(1,423.0)	95.7
7	Хангамжийн материал	25,000.0	24,246.5	(753.5)	96.9
8	Гэрэл цахилгаан	6,720.0	4,824.6	(1,895.4)	71.8
9	Дулаан	10,200.0	6,443.4	(3,756.5)	63.1
10	Цэвэр бохир ус	5,760.0	1006.50	(4,753.5)	17.5
11	Шуудан холбоо	13,876.8	11,059.7	(2,817.1)	79.7
12	Томилолт / дотоод/	98,173.6	39,747.0	(58,426.5)	40.5
13	Томилолт / Гадаад/	130,965.9	90,861.3	(40,104.6)	69.4
14	Засвар үйлчилгээ	62,068.2	57,516.0	(4,552.2)	92.7
15	Татвар хураамж	231,843.3	199,191.0	(32,651.3)	85.9
16	Түрээс	3,240.0	2,394.1	(845.9)	73.9
17	Маркетинг- зар сурталчилгаа	90,682.8	86,031.4	(4,651.4)	94.9
18	Сургалт	28,570.0	23,564.5	(5,005.5)	82.5
19	Хяналт мониторинг	24,000.0	14,100.0	(9,900.0)	58.7
20	Хөрөнгө худалдан авах	89,655.0	88,079.4	(1,575.6)	98.2
21	Төсөл хөтөлбөр	731,654.4	732,577.2	922.8	100.1
22	Элэгдлийн зардал	168,000.0	146,895.2	(21,104.8)	87.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,917,092.5	3,596,246.4	(320,846.1)	91.8
	Үйл ажиллагааны бус зардал				
	Дамжуулан зээлийн хүүгийн төлбөр	2,900,000.0	2,695,634.7	(204,365.3)	92.9
	Үйл ажиллагааны бус зардлын дүн	2,900,000.0	2,695,634.7	(204,365.3)	92.9
	Нийт зардлын дүн	6,817,092.5	6,291,881.0	(525,211.5)	92.3
	Татварын өмнөх ашиг	4,498,200.9	5,653,819.4	(1,155,618.5)	25.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Зээлийн батлан даалтын сан, түүний үйл ажиллагаа

Зээлийн батлан даалтын сан нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулиар тусгайлан байгуулагдсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий батлан даалтын сангийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

ЗБДС нь сангийн тухай хуульд заасан дараах чиглэлүүдээр үндсэн үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасны дагуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээс гаргасан хаалттай өрийн бичгээс банк, санхүүгийн байгууллага худалдаж авсан бол уг худалдаж авсан өрийн бичигт батлан даалт гаргах;
- Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60.0 хүртэлх хувьд батлан даалт гаргах.

ЗБДС нь үндсэн үйл ажиллагаатайгаа холбогдуулж дараах бусад үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Зээлийн мэдээлэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хариуцсан эрх бүхий байгууллага, шаардлагатай бусад төрийн болон хувийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, лавлагаа авах;
- Зээлийн батлан даалт болон холбогдох бусад үйл ажиллагаанаас бий болсон хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулах зорилгоор тэдгээрийг бусдад худалдах, хуулиар зөвшөөрсөн бусад арга хэмжээг авах.

3.2 Зээлийн батлан даалтын сангийн гадаад, дотоод орчин

Зээлийн батлан даалтын сан нь Зээлийн батлан даалтын сангийн тухай, Сангийн Удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан "Сангийн дүрэм", түүнд нийцүүлэн гаргасан 16 журам, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан дотоод үйл ажиллагааг зохицуулах 7 журам үйлчилж байна.

Тайлант хугацаанд ЗБДС-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль.

ЗБДС-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын томоохон өөрчлөлт тайлант онд ороогүй байна. Харин Сангийн Удирдах зөвлөлийн 2023 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 01 тогтоолоор "Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт батлан

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

даалт гаргах хамтран ажиллах гэрээ"-г арилжааны банкнуудтай байгуулж ажиллахыг Сангийн гүйцэтгэх захиралд зөвшөөрснөөр энэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлж эхэлсэн байна.

ЗБДС-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь ЗБДС-ийн өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг байна.

ЗБДС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 8 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан дүрмийн 3.8.7 дах хэсэгт заасны дагуу Хяналтын зөвлөл /3 гишүүнтэй/ нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Сангийн дүрэм, холбогдох журам, Удирдах зөвлөлийн шийдвэр, Удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт зэрэгт хяналт тавьж, дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын дэргэд гүйцэтгэх захирлын гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий дотоод хяналтын ажилтан ажиллаж байна. Харин эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгж нь ЗБДС-ийн явуулж буй үндсэн үйл ажиллагааны батлан даалтын нэгж болон салбарын эрсдэлүүдтэй холбоотой асуудлуудыг хянаж дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.

ЗБДС-ийн дүрэмд заасан Хяналтын зөвлөлийн чиг үүрэг, ажлын тайлан, Эрсдэлийн удирдлагын газрын болон дотоод хяналтын ажилтны ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ЗБДС-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЗБДС-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлуулсан бөгөөд 2023 онд бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

ЗБДС-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус сангийн үйл ажиллагаанд тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу ЗБДС-ийн 2023 оны санхүүгийн тайланг

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

бэлтгэсэн нь Сангийн Удирдах зөвлөлийн 2022 оны 26 дугаар тогтоолоор баталсан ЗБДС-ийн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т заасан Сангийн сайдын 386 тоот тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар"-тай нийцээгүйг аудитын явцад хөрвүүлж, зааврын дагуу санхүүгийн тайланг дахин бэлтгэн ирүүлсэн.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 704.2 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	159,127,070.9	186,852,736.0	27,725,665.1
Авлага	51,847,515.3	29,871,908.9	(21,975,606.4)
Бараа материал	49,378.9	58,838.5	9,459.6
Үндсэн хөрөнгө	47,357,745.2	42,302,406.5	(5,055,338.7)
Нийт хөрөнгө	258,381,710.3	259,085,889.9	704,179.6
Өр төлбөр	179,741,596.9	174,690,236.7	(5,051,360.2)
Цэвэр хөрөнгө	78,640,113.4	84,395,653.2	5,755,539.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	258,381,710.3	259,085,889.9	704,179.6

Хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дансууд байна.

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 186,852.7 сая төгрөг болж, 27,725.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төслийн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгө дансанд байршсан хадгаламж 22,343.5 сая төгрөг, төслийн дэд данс болон аж ахуйн үйл ажиллагааны зориулалтаар ашиглагддаг харилцах данс 3,247.7 сая төгрөг, сангийн өөрийн хөрөнгө, нөөц сангийн хөрөнгийг байршуулсан хадгаламжийн данс 2,134.6 сая төгрөгөөр тус тус өссөн;
- Авлагын дансны үлдэгдэл 29,871.9 сая төгрөг болж 21,975.6 сая төгрөгөөр буурсан нь дансны авлага буюу үүрэг гүйцэтгэл, батлан даалтын шимтгэлийн авлага 1,845.8 сая төгрөг, байгууллагаас авах авлага 11.4 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 30.7 сая төгрөгөөр өсөж, бусад авлага дансанд бүртгэлтэй төслөөс авах санхүүжилтийн болон хүүгийн авлагын дансны үлдэгдэл 23,863.5 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Сангийн яамны зөвшөөрлөөр төслийн дансанд байршиж байсан мөнгөн хөрөнгөөс сангийн данс руу шилжүүлэн батлан даалт гаргаснаас төслөөс авах санхүүжилтийн авлага 22,597.6 төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 42,302.4 сая төгрөг болж, 5,055.3 сая төгрөгөөр буурсан нь 88.1 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан, 22 ширхэг суурин компьютерт 19.1 сая төгрөгөөр засвар хийж капиталжуулсан зэргээс шалтгаалан өсөж, ТӨБЗГ-н 2023 оны 26 дугаар тогтоолын дагуу 90.0 сая төгрөгийн үнэтэй, 74.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй Ландкрузер маркийн тээврийн хэрэгслийг Дорнод аймгийн ЗДТГ-т шилжүүлж данснаас хассан, 146.8 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан, "Ажлын байрыг дэмжих" зээлийг батлан даахад зориулсан 2021 оны 12/02-02 дугаар гэрээний дагуу Хүнс,хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Хадгаламжийн даатгалын корпорацад 5000.0 сая төгрөгийг шилжүүлж, урт хугацаат хөрөнгө оруулалт дансыг 5000.0 сая төгрөгөөр бууруулж, урт хугацаат өр төлбөр данс руу хаасан;

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 174,690.2 сая төгрөг болж 5,051.4 сая төгрөгөөр буурахад МУЗГ-аас хэрэгжүүлж буй Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх “10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн 4 талт гэрээний графикт төлбөрийг ХХААХҮЯ-наас Хадгаламжийн даатгалын корпорацад төлсөн 5,000.0 сая төгрөг, Төв аймгийн ЗДТГ-аас гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтын эх үүсвэр 100.0 сая төгрөгийг буцаан татсан;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 84,395.6 сая төгрөг болж, 5,755.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Сангийн Удирдах зөвлөлийн 2022 оны 23 дугаар “Сангийн 2023 оны төсвийг батлах тухай” тогтоолоор Сангийн 2023 оны орлого, зардал, хүрэх үр дүнг, 25 дугаар “Сангийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай” тогтоолоор Сангийн 2023 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалт, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, хэрэгжүүлэх хугацаа зэргийг агуулсан төлөвлөгөөг тус тус баталсан байна.

Сангийн Удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Сангийн 2023 оны үйл ажиллагааны төсвийг тодотгол хийж, тодотголоор үйл ажиллагааны бусад орлогыг 131.7 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Энэхүү шинэчлэн баталсан тогтоолын дагуу тайлант оны нийт орлогыг 11,315.3 сая төгрөг, нийт зардлыг 6,817.1 сая төгрөгөөр тооцож, 4,498.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 11,945.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,291.8 сая төгрөгийн зардал гарган, 5,653.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 11,945.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 630.4 сая төгрөг буюу 5.6 хувиар давж биелэхэд хугацаатай хадгаламжийн хүүгийн орлого 549.4 сая төгрөг буюу 5.3 хувиар, батлан даалтын шимтгэлийн орлого 76.8 сая төгрөг буюу 9.8 хувиар, Азийн батлан даалтын сангуудын 35-р чуулганыг зохион байгуулснаас олсон орлого 5.7 сая төгрөг буюу 4.3 хувиар давж биелсэн нь нөлөөлжээ. Харин хураамжийн орлого 1.5 сая төгрөг буюу 13.9 хувиар тасарсан байна.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 3,596.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 320.8 сая төгрөг буюу 8.2 хувиар бага байгаа нь үйл ажиллагааны 21 төрлийн үйл ажиллагааны зардлуудыг дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр ашиг татварын өмнөх ашиг 5,653.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,155.7 сая төгрөгөөр давж биелсэн нь хадгаламжийн хүүгийн орлого 549.4 сая төгрөг, батлан даалтын шимтгэлийн орлого 76.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагааны зардал 320.8 сая төгрөг, дамжуулан зээлийн хүүгийн төлбөр 204.3 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлон нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын тайланд Зээлийн батлан даалтын сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийн аудитор Ц.Орхонтамир, аудиторын туслах ажилтан О.Отгончимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Д.Уранчимэг, компанийн захирал Д.Шийрэв нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитын менежер Ч.Болд, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зээлийн батлан даалтын сан 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 1/234 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Зээлийн батлан даалтын сангийн нягтлан бодох бүртгэлийн Даймонд программын мэдээллийн бааз 2024 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр ransomware төрлийн халдлагад өртөж санхүүгийн программын мэдээллийн бааз устсан бөгөөд байгууллагын санхүүгийн ажилтнууд 2023 оны тайлангийн эхний үлдэгдэл, холбогдох бүх гүйлгээг программ руу дахин оруулж санхүүгийн тайланг бэлтгэсэн нь аудитыг төлөвлөсөн хугацаанд нь дуусгахад сөрөг нөлөө үзүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Сангийн 2023 оны хагас жилээр бэлтгэгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны эхний хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,377.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 13.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Энэ нь материаллаг байдлын суурь үзүүлэлт буюу орлогын дэлгэрэнгүй тайланг жилийн дүнгээр авч үзэх нь зохимжтой гэж үзсэн тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 6,194.9 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 61.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага өмнөх онд хийгдэж байсан холбогдох арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хуульд заасан хязгаарлалт, шаардлагуудыг хангаж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 6.1, 7.1, 8.1, 9-15 дугаар зүйлд заасан хязгаарлалтуудыг мөрдөж ажилласан эсэхийг холбогдох санхүүгийн баримт, бичиг, тушаал шийдвэртэй тулгаж шалгахад ямар нэгэн зөрчил илрээгүй. Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.4 дэх заалтыг хэрэгжүүлж дэд даргын чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгоогүй, түүнд албан тушаалтныг томилоогүй;
- Сургалтыг цахимаар зохион байгуулсан;
- Дотоод мэдээ тайланг дотоод сүлжээ ашиглан солилцдог болсноор принтерийн хор, бичгийн цаас, цахилгааны хэмнэлт гаргах арга хэмжээ авсан байна.

Тайлант онд цахим дэлгүүрээс 8.9 сая төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зээлийн батлан даалтын сан нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2023 онд нийт 205,145.6 сая төгрөгийн дүн бүхий 157 мэдээлэл байршуулахыг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сангийн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу 896.9 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 701.8 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдаж авснаас нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар 505.8 сая төгрөгийн 2 төрлийн ажил, үйлчилгээ, харьцуулалтын аргаар 139.4 сая төгрөгийн 3 төрлийн бараа, ажил, үйлчилгээ, шууд худалдан авалтаар 47.7 сая төгрөгийн 7 төрлийн хангамжийн материал, бичиг хэрэг, түлш, шатахуун, цахим дэлгүүрээс 8.9 сая төгрөгийн компьютер, техник хэрэгслийг тус тус худалдан авсан байна. Дээрх худалдан авалтуудыг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль, эрх зүйн бичиг баримтууд болон 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, өглөгийн данстад тулган шалгах горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илрүүлсэн нийт 73.6 сая төгрөгийн зөрчлийг шалгагдагч байгууллагад танилцуулж, залруулагдсан зөрчлийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6.9 сая төгрөгийн дүнтэй 6 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	6	6,859.12	6	6,859.12	100.0
Нийт дүн	6	6,859.12	6	6,859.12	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Үүрэг гүйцэтгэлийн өглөг дансны үлдэгдэлтэй холбоотой асуудлыг Хяналтын зөвлөлөөр хянуулж Сангийн Удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлсэн эсэх;
2. Удирдах зөвлөлийн 2022 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан Зээлийн батлан даалтын сангийн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т заасны дагуу санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагад мөрдөх дансны нэгдсэн жагсаалт", "Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэх талаар хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийг хянах;
3. Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Улсын ахлах байцаагчийн 2023 оны 01/01-07, 02/01-07, 03/01-07 дугаартай актаар албан хаагчдад тогтоосон төлбөрийн актыг байгууллагын төсвөөс төлсөн асуудлыг дээд шатны төсөв захирагчийн дотоод аудитын нэгжийн анхааралд хандуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 85.1 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 2 иргэнд ажилгүй байсан хугацааны цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд байгууллагын төсвөөс 21.7 сая төгрөг төлснийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх авлага үүсгээгүй;
- "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний үндсэн дээр олгосон 29.7 сая төгрөгийн ажлын хөлсөнд НДШ тооцож төлөөгүй;

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- Татварын системд бүртгэгдээгүй баримтаар 39.1 сая төгрөгийн томилолтын зардлын тооцоог хийсэн;
- Шүүхийн тэмдэгтийн хураамжийн төлбөрт шилжүүлсэн 20.5 сая төгрөгийн авлагаар бүртгээгүй зэрэг болно.

Аудитаар нийт 4,524.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 10.3 төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаатай бүртгэл хөтөлсөн, хууль журмын мөрдөлттэй холбоотой 4,514.3 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

Аудитаар илэрсэн 4,524.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 61.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Улсын ахлах байцаагчийн 2023 оны 01/01-07 дугаартай актаар тогтоосон 5.0 сая төгрөг, 02/01-07 дугаартай актаар тогтоосон 1.0 сая төгрөг, 03/01-07 дугаартай актаар тогтоосон 4.3 сая төгрөг, нийт 10.3 сая төгрөгийн актын төлбөрийг байгууллагын хөрөнгөнөөс төлж барагдуулсан, гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"; 6 дугаар зүйл 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь

Тогтоосон төлбөрийн актыг буруутай этгээдээр төлүүлээгүй, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зээлийн батлан даалтын сан нь НБББББ-ийн үндсэн зарчим хэсэгт санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 386 тоот тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагад мөрдөх дансны нэгдсэн жагсаалт", "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг мөрдөнө гэж тусгасан боловч 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2022 оны

**ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

26 дугаар тогтоолоор батлагдсан Зээлийн батлан даалтын сангийн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн Санхүүгийн тайлангийн үндсэн зарчим хэсэгт Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 386 тоот тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагад мөрдөх дансны нэгдсэн жагсаалт", "Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу СТОУС, НББОУС-ын шаардлагад нийцүүлэн гаргахад дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд: 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх бөгөөд тайлант үеийн турш тууштай хэрэгжсэн байна. ..." гэж заасантай, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЖДҮХС-ийн санхүүгийн тайланг "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т тусгасан бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмын дагуу бэлтгэн, тайлагнаж байх.

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үүрэг гүйцэтгэлийн өглөг дансанд өмнөх оноос шилжин ирсэн 4,514.3 сая төгрөгийн тодорхой бус өглөг хуримтлагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн үүрэг гүйцэтгэлийн өглөг дансны бичилт, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг Хяналтын зөвлөлөөр нягтлан шалгуулж, гарсан шийдлийг сангийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Захирааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 182/ШШ2023/02864, 182/ШШ2023/01735 тоот захирамжуудаар тогтоогдсон нэр бүхий 2 ажилтны ажиллаагүй хугацааны цалин хөлс 19,013.94 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 2,376.74 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж 0,25 сая төгрөг, нийт 21,642.68 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн.	1	21,642.7					1	21,642.7	1	
2023 оны 1-11 дүгээр саруудад Татварын системд бүртгэгдээгүй баримтаар томилолтын зардлын тооцоог хийсэн	1	39,106.2					1	39,106.2		
Шүүхийн тэмдэгтийн хураамжийн төлбөрт шилжүүлсэн дүнгүүдийг авлага үүсгээгүй зардалд бүртгэсэн байсан.	1	20,532.7					1	20,532.7		
2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Б.Дэлгэржаргалтай байгуулсан №2022/ТТ/АГ/01 дугаартай "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний үндсэн дээр 2023 оны 1-9 дүгээр сард олгосон 29,700.00 мянган төгрөгийн ажлын хөлсөнд НДШ тооцож төлөөгүй	1	3,712.5					1	3,712.5		
Дүн	4	85,079.7					4	85,079.7		

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Үүнээс												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үүрэг гүйцэтгэлийн өглөг дансанд өмнөх оноос шилжин ирсэн 4,514.3 сая төгрөгийн тодорхой бус өглөг хуримтлагдсан байна.	1	4,514,310.0					1	4,514,310.0				
Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Улсын ахлах байцаагчийн 2023 оны 01/01-07 дугаартай актаар тогтоосон 5.0 сая төгрөг, 02/01-07 дугаартай актаар тогтоосон 1.0 сая төгрөг, 03/01-07 дугаартай актаар тогтоосон 4.3 сая төгрөг, нийт 10.3 сая төгрөгийн актын төлбөрийг байгууллагын хөрөнгөнөөс төлж барагдуулсан, гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	10,300.0			1	10,300.0						
Дүн	1	4,524,610.0			1	10,300.0	1	4,514,310.0				

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга			Нийт зөрчил		Үүнээс						Зөвлөмж	
					Төлбөрийн акт		Албан шаардлага					
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зээлийн батлан даалтын сан нь НБББББ-ийн үндсэн зарчим хэсэгт санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 386 тоот тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагад мөрдөх дансны нэгдсэн жагсаалт", "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг мөрдөнө гэж тусгасан боловч 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэж, тайлагнасан байна.												
Нийт дүн												

/Мянган төгрөгөөр/



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 817/А0150127

Улаанбаатар хот

СНАГ-2024/56/НА-УТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Улсын ахлах байцаагчийн 2023 оны 01/01-07, 02/01-07, 03/01-07 дугаартай актаар албан хаагчид тогтоосон 10,300,000.00 /арван сая гурван зуун мянган/ төгрөгийн төлбөрийн актыг байгууллагын төсвөөс төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д "Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасны дагуу **ШААРДАХ нь:**

1. Нэр бүхий албан хаагчдад тогтоосон төлбөрийн актыг өөрсдөөр нь төлүүлээгүй зөрчлийг арилгах биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зээлийн батлан даалтын сангийн Гүйцэтгэх захирал /С.Цогтсайхан/, нягтлан бодогч /Т.Пунсалдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД

Д.ШИЙРЭВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0325 SNAG-43.Docx

0001081229